# БАЯНХОНГОР АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН
# 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 09 | Номгон

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Зорилт 1. Байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хөгжлийн бодлогыг тодорхойлно. | | | | | | | | | |
| 1.1. | УИХ, ЗГ, яам, агентлаг, орон нутгийн төр захиргааны байгууллагаас боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, дагаж мөрдөх журмын төсөлд санал өгөх | Байгууллагын төсөв | Саналын тоо | 5 | 1 | 1 | 2 | Аймгийн засаг даргын тамгын газрын хууль эрх зүйн хэлтэст 4/422 дугаартай албан бичгээр "Төрийн албаны тухай хуулийн" нэмэлт өөрчлөлтөд санал хүргүүлсэн. Баянхонгор аймгийн газрын харилцаа хот байгуулалтын "Газрын тухай хууль"-ийн нэмэлт өөрчлөлтөд санал хүргүүлсэн | 100% |
| 1.2. | Засгийн газар, орон нутгийн төр захиргааны байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах **https://bayankhongor.igovernment.mn** | Байгууллагын төсөв | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2026 оны 1-р улирлыг тайланг баталгаажуулж 63 хувьтай үнэлэгдсэн. Мөн Аймгийн засаг даргын захирамжийн хэрэгжилтийн 1-р | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | улирлын тайланг баталгаажуулж хяналтад авсан. Мөн D-PARLIAMENT-Д Худалдан авах ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шатанд явж байгаа бөгөөд үүнийг газрын фэйсбүүк фэйж хуудас болон сайтад линкийг байршуулж олон нийтэд түгээж ажиллаж байна. | |
| Зорилт 2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулна. | | | | | | | | | |
| 2.1 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж, үр дүнг тухай бүр ил тод мэдээллэх **www.tender.gov.mn** | Байгууллагын төсөв | Үр дүнтэй зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тоо | 35 | 20 | 0 | 22 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөнд 27 нэр төрлийн 10,0 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдснөөс хагас жилийн байдлаар 9.0 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулж холбогдох хууль, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | журмын дагуу төсөл арга хэмжээ тус бүрийн гарсан үр дүнг тухай бүр цахим системд нийтлэж, ил тод мэдээллэсэн ба тендер шалгаруулалтын үр дүнд аймгийн орон нутгийн төсөвт 212,1 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг гарган ажиллаад байна. | |
| Зорилт 3. Тухайн жилийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөө болон төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжиж ирсэн захирамжуудын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулна. | | | | | | | | | |
| 3.1 | Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2027 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулах | Орон нутгийн төсөв | Батлагдсан төлөвлөгөөний тоо | 1 | 0 | 1 | Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээж батлуулдаг ба 2027 оны | | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөвлөгөө батлуулах хугацаа болоогүй. | | |
| 3.2 | Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн болон харьяа байгууллагуудын 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тайлагнах **www.tender.gov.mn** | Байгууллагын төсөв | Биелэлтийн хувь | 29 | 0 | 29 | Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахим системээр тайлагнадаг ба тайлагнах хугацаа болоогүй | | 100% |
| 3.3 | Улсын болон олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | 0 | 5 | 0 | 7 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төлөвлөгөөнд хандиваар буюу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтөөр санхүүжигдэх 3,8 тэрбум төгрөгийн 2 төсөл арга тусгагдсан ба худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тухайн онд аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 7 төсөл арга хэмжээнээс 5 төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлж авахаар төлөвлөсөн боловч холбогдох яамдаас эрх шилжүүлээгүй ТХААГазарт 6, ОБЕГазарт 1 төсөл арга хэмжээ зарлагдсан. | |
| 3.4 | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | 30 | 9 | 0 | 9 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | санхүүжигдэх 4,2 тэрбум төгрөгийн 12 төсөл арга тусгагдсан ба эхний хагас жилийн байдлаар 9 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | |
| 3.5 | Замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | 7 | 5 | 0 | 5 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 791.5 сая төгрөгийн 5 төсөл арга тусгагдсан ба эхний хагас жилийн байдлаар 5 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | 100% |
| 3.6 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | 9 | 5 | 0 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд замын сангийн хөрөнгө | | 60% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оруулалтаар санхүүжигдэх 939.1 сая төгрөгийн 5 төсөл арга тусгагдсан ба эхний хагас жилийн байдлаар 3 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | | |
| 3.7 | Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Арга хэмжээний тоо | 0 | 3 | 0 | 3 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 190,0 сая төгрөгийн 3 төсөл арга тусгагдсан ба эхний хагас жилийн байдлаар 3 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | 100% |
| Зорилт 4. Худалдан авах ажиллагааны талаар төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад тухай бүр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана. | | | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход холбогдох хууль, журам, цахим системээр хэрхэн материал илгээх талаар тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | Байгууллагын төсөв | Зөвлөгөө өгсөн тоо | 68 | 30 | 20 | 40 | Цахим худалдан авах ажиллагаанд оролцоход холбогдох хууль, журам, цахим системээр хэрхэн материал илгээх талаар тухай бүр мэргэжил арга зүйн зөвлөгөөг хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 40 аж ахуй нэгж, 20 иргэнд өгч, А3 гэрчилгээ олгох шалгалтыг 1 удаа зохион байгуулахад 73 хараат бус гишүүн албан хаагчийн төлөөллийг хамруулсан. | 100% |
| 4.2 | Худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг эрх бүхий албан тушаалтанд Төрийн болон орон өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон холбогдон гарсан эрх зүйн акт, цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар сургалт зохион | Байгууллагын төсөв | Сургалтын тоо | 6 | 2 | 1 | 4 | Тус оны хагас жилийн байдлаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх 4 сургалтыг зохион байгуулан ажиллаа. Үүнд : 1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | | | | | | | ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журмын танилцуулах сургалтыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдөр.<br>2. Шинээр томилогдсон сумдын санхүү албаны дарга нарт худалдан авах ажиллагаанд анхаарах, танилцуулах сургалтыг 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр.<br>3. Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс АТГ-ын мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, албан хаагчдад хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтад холбогдох хууль, журмын танилцуулга, худалдан авах ажиллагаа зохион | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулахад анхаарах асуудлуудын талаарх сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр . 4. “Боловсролыг дэмжих жил”-ийн хүрээнд аймгийн ХХААГ, 13-р цэцэрлэг, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн хамт олонд байгууллагын үйл ажиллагаа танилцуулах болон худалдан авах ажиллагаанд анхаарах шаардлагатай асуудлуудын талаарх сургалтыг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр тус тус зохион байгуулсан. | |
| 4.3 | Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А3 гэрчилгээ олгох шалгалтыг зохион байгуулах | Байгууллагын төсөв | Шалгалтын тоо | 6 | 1 | 1 | 1 | Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А3 сертификатын шалгалтыг 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 3 ээлжээр зохион байгуулж, шалгалтад төрийн болон бусад байгууллагаас | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | захиалга өгсөн албан хаагч, хараат бус гишүүдийн 64 төлөөллийг хамруулсан. | |
| 4.4 | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх | Байгууллагын төсөв | Вэбсайтад байршуулсан мэдээллийн тоо | 34 | 15 | 10 | 15 | Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тайлант хугацаанд байгууллагын албан ёсны цахим хуудас (вэбсайт)-аар дамжуулан үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлсэн арга хэмжээ болон холбогдох шийдвэрийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд нээлттэй байршуулж, ил тод байдлыг хангаж ажилласан байна. Мөн shilen.gov.mn сайтад 1-р улирлын мэдээг хүргүүлсэн | 100% |
| **Зорилт 5. Байгууллагын программ хангамжийн аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 5.1 | Албан хаагчдын ашиглаж байгаа компьютерүүдэд вирусны программ суулгах | Байгууллагын төсөв | Программ суулгасан компьютерийн тоо | 9 | 0 | 9 | 0 | Вирусны програмны лицензны дуусах хугацаа болоогүй. Сүүлийн хагас жилд хэрэгжинэ. | 100% |
| **Зорилт 6. Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тендерт оролцохыг сонирхсон аж ахуйн нэгжүүдийг өрсөлдөх тэгш боломжоор хангаж ажиллана.** | | | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход шаардлагатай тоон гарын үсэг олгох, тоон гарын үсгийн сунгалтыг тогтмол хийх | Байгууллагын төсөв | Шинээр олгосон тоон гарын үсгийн тоо | 39 | 15 | 15 | 20 | Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдэд цахим худалдан авах ажиллагаанд оролцоход шаардлагатай тоон гарын үсгийг 2026 онд шинээр 15 аж ахуйн нэгжид олгохоор төлөвлөсөн ба хагас жилийн байдлаар 20 ширхгийг олгосон. | 100% |
| | | | Сунгалт хийсэн тоон гарын үсгийн тоо | 25 | 7 | 8 | 11 | Хагас жилийн байдлаар тоон гарын үсгээ сунгуулахаар хүсэлт гаргасан 11 аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийн сунгалтыг ажилласан. | 100% |
| 6.2 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан хугацаанд шийдвэр гаргах, шийдвэр гарснаас хойш ажлын 5 өдрийн хугацаанд худалдан авах ажиллагааны цахим системээр шийдвэр нийтлэхэд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг хамтад нь байршуулж, хүсэлт гаргасан оролцогчид танилцуулах | Байгууллагын төсөв | Нийтэлсэн төсөл арга хэмжээний тоо | 35 | 20 | 0 | 22 | Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны худалдан авах ажиллагааны тодотгосон төлөвлөгөөнд нийт 27 нэр төрлийн 10,0 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдснөөс хагас жилийн байдлаар 9.0 тэрбум төгрөгийн 22 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn-ээр 100% зохион байгуулж, хуульд заасан хугацаанд захиалагчийн шийдвэр, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг хамтад нь тухай бүр байршуулж, үр дүнг нийтэлж, гэрээг цахим системд бүртгэсэн. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Төрийн захиргааны удирдлага зохион байгуулалтыг хангана.** | | | | | | | | | |
| **Зорилт 7. Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа, хүний нөөц, сургалт, архив, албан хэрэг хөтлөлт, гадаад харилцаа, санхүү, аж ахуй, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөлт хийж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | | | |
| 7.1 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Байгууллагын 2026 оны авилгын эсрэг төлөвлөгөөг баталсан. Аймгийн Прокурорын газар болон Цагдаагийн газраас зохион байгуулсан Авлигатай тэмцэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа аянд оролцож байгаа. | 100% |
| 7.2 | Яам, агентлаг, аймгийн Засаг дарга, холбогдох газар, хэлтсээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | Байгууллагын төсөв | Биелэлтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн газраас 64 дугаартай “Цахим систем нэвтрүүлэх ажлын зөвлөмж, албан даалгавар” ирсэний | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дагуу байгууллагын нийт албан хаагчийг цахим системд бүртгэж эд хөрөнгө тоолох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Баянхонгор аймгийн засаг даргын 1а/380 дугаартай албан даагаврын хүрээнд төлөвлөгөө боловсруулсан. https://bayankhongor.igovernment.mn сайтын аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн тайланг цаг тухайд нь баталгаажуулсан. | |
| 7.3 | Байгууллагын ERP- системийн ашиглалтыг сайжруулж, ирсэн явсан бичгийн эргэлтийг албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлагад нийцүүлэн хөтлөж, архивлах | Байгууллагын төсөв | Албан бичиг шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Нийт 185 бичиг ирснээс шийдвэрлэсэн 137, тендертэй холбоотой судлагдаж байгаа 15, үйлдэл хянах 29, буцаасан 16 бичгийг ERP системийг ашигласан байна. | 100% |
| | | | Архивд хүлээлгэн өгсөн архивын нэгжийн тоо | 149 | 50 | 50 | 50 | Тендерийн баримт бичигт хяналт шалгалт дуусаагүй тул 2025 оны баримт 100 хувь хүлээн аваагүй болно. | 50 |
| 7.4 | Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, | Байгууллагын төсөв | Шилэн дансны ил тод хөтлөлт, | 100% | 100% | 100% | 98.8% | Тендерын баримт бичгийн хураамжийн төлбөр сангийн | 98.8% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангах | | тайлан мэдээ гаргалтын хувь | | | | | яамнаас шилжиж ирэх хугацаа болоогүй тул санхүүжилт тасалдсан. | |
| | | | Төсвийн үр дүнтэй зарцуулалтын хувь | 100% | 100% | 100% | 90% | | 90% |
| 7.5 | Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих ерөнхий шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу албан хэргийг хос бичгээр хөтлөх | Байгууллагын төсөв | Кирилл болон үндэсний бичгээр хөтөлсөн албан бичгийн тоо | 308 | 100 | 150 | 172 | Бусад байгууллагад явуулсан албан бичиг 123, тушаал - 15, Зөвлөмж 34 тус тус крилл болон үндэсний бичгээр хосолж хөтөлсөн. | 100% |
| 7.6 | Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах арга хэмжээг сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв, Байгууллагын төсөв | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу шинэ албан хаагчдад зориулсан гарын авлага бэлтгэх ажил 50 хувьтай хэрэгжиж байна. Мөн албан хаагчдад Насан туршын суралцахуйн төвөөс сургалт авах хүсэлт явуулж 5 албан хаагч Монгол бичгийн сургалтад хамрагдсан ба дараагийн сургалт 9 сард авахаар төлөвлөгөөнд туссан. Мөн Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсээс Төрийн албан хаагчын ёс зүйн сэдвээр сургалт | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авч 5 албан хаагч хамрагдсан. | |
| | | | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 5 | 1 | 1 | 5 | Сургалтын төлөвлөгөөн туссан сургалтуудад цаг тухай бүрд нийт албан хаагчдын хамруулж байгаа | 100% |
| Зорилт 8. Байгууллагын гүйцэтгэлийг тайлагнах үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 8.1 | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлт, үр дүнг тайлагнах | Байгууллагын төсөв | Биелэлтийн хувь | 100% | 100% | 100% | 63.04% | Тайланг цаг тухай бүрд хугацаанд нь тайлагнаж байгаа ба 1-р улирлын байдлаар | 63.04 % |
| Зорилт 9. Дотоод хяналт шалгалтын ажлыг сайжруулж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 9.1 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд дотоод хяналт шалгалт хийх | Байгууллагын төсөв | Шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтаар тайлант үед гомдол, мэдээлэл хагас жилийн байдлаар бүртгэгдээгүй. | 100% |
| 9.2 | Газрын даргаас өгсөн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээнд дотоод хяналт, шалгалт хийж хангалтгүй, дунд үнэлгээ авсан албан хаагчдын ажлыг сайжруулж сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх | Байгууллагын төсөв | Тухайн жилийн газрын даргаас өгсөн үнэлгээний түвшин гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | 100% | | Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээнд дотоод хяналт шалгалт хийх ажлын хэрэгжилтийг хянахад, тайлант хугацаанд албан хаагчдын | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх, үнэлгээ өгөх хуулиар тогтоосон хугацаа болоогүй байна. Үүнтэй холбогдуулан хангалтгүй болон дунд үнэлгээ авсан албан хаагчдын ажлыг сайжруулах, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр авах дараагийн шатны арга хэмжээнүүд нь үнэлгээний нэгдсэн дүн албажсаны дараа хэрэгжихээр хүлээгдэж байна. | |
| 9.3 | Байгууллагын төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийх | Байгууллагын төсөв | Байгууллагын төсвийг хуваарийн дагуу зарцуулсан хувь | 100% | 100% | 100% | 100% | Байгууллагын төсвийн орлого, зарлага болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтаар төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан байдал, орлогын бүрдүүлэлт болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг анхан | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шатны баримт материалтай тулган хянахад санхүүгийн болон журмын ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй болно. Төсвийн гүйцэтгэл тогтоосон норм, нормативын дагуу хэрэгжсэн байна. | |
| 9.4 | Байууллагын хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, хөдөлмөрийн харилцаанд хяналт шалгалт хийх | Байгууллагын төсөв | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | 100% | 100% | Шалгалтаар албан хаагчдын цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга бат, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт болон хөдөлмөрийн гэрээний заалтуудын биелэлтийг хянахад Seruous (ноцтой) зөрчил, дутагдал илрээгүй болно. Албан хаагчид хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд хөдөлмөрийн харилцаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэвийн үргэлжилж байна. | 100% |
| 9.5 | Байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлд хяналт шалгалт хийх | Байгууллагын төсөв | Хяналт шалгалт хийсэн хувийн хэргийн тоо | 5 | 5 | 0 | 5 | Шалгалтаар албан хаагчдын ажилд орсон тушаал, шийдвэр, томилгооны баримт бичиг, | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | боловсролын диплом, гэрчилгээний хуулбар, иргэний баримт бичгүүд болон бусад заавал байх ёстой материалуудыг нэг бүрчлэн тулган хянахад хувийн хэргийн бүрдэл дутуу буюу журам зөрчсөн тохиолдол илрээгүй болно. Албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, хөтлөлтийг шинэчлэгдсэн журам стандартын дагуу бүрэн хангасан байна. | |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
.................................... Э.ЭНХБАТ

.... оны ... дугаар сарын ...

ТАЙЛАГНАСАН:
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
.................................... Н.БЯМБАДОРЖ

2026 оны 06 дугаар сарын 09